



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



**Агуулга**

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	8
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар... 8	
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал .....	10
3.2	Төсөвт зардалтай холбоотой асуудал.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийгдсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
5	Аудитын явцад илэрсэн зөрчил .....	18
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэргийн яам
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 855  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт


Улсын Их Хурлын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын Их Хурлын даргын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Гомбожавын Занданшатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн батлагдсан төсвийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, төсөвт зардалтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-наас 2019 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Отгонхорлоо, гэрээт аудитор Ш.Гүрпүрэв нар гүйцэтгэв.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 14/461 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэн, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулж баримтжуулсан болно.



Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгон, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын Их Хурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Улсын Их Хурал нь хууль тогтоох болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Бие даасан 27 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 112 хууль, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай 14 хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай 9 хууль, Улсын Их Хурлын 89 тогтоолыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан,
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулан “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий” ажлын хэсгийг байгуулж, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасны дагуу холбогдох 7 байгууллагад төслийг хүргүүлсэн,
- Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хороодын тогтоолоор байгуулагдсан хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий 20 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн,
- Улсын Их Хурлын чуулганы 60 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 192, дэд хороодын 14, түр хорооны 2 удаагийн хуралдааныг хэвийн явуулах бэлтгэлийг хангасан,
- Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар 621 хуудас товч тэмдэглэл хөтөлж, 4331 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулган, хянан нийлж, 5820 хуудас хавсралт баримт бичгийн хамт нийт 10772 хуудас материалыг архивд шилжүүлсэн,
- Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд шуурхай түгээж, 28-30 минутын 57 нэвтрүүлэг, 227 видео мэдээ бэлтгэн [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудас болон youtube.com, facebook.com гэх зэрэг нийгмийн сүлжээнд байршуулж, телевизүүдээр дамжуулсан,
- Монгол Улсын Их Хурал НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд Парламентын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах нь” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн орнуудын парламентчдын ээлжит зөвлөгөөнийг 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.
- Улсын Их Хурлын Цахим архив бүрдүүлэх ажлын хүрээнд 1990-2016 оны баримтыг “Төрийн архивын тоо бүртгэл-мэдээллийн АМС” программд оруулсны зэрэгцээ УИХ-ын гишүүн, намын бүлэг, Тамгын газрын ажилтнуудын ажлын хэрэгцээ болон бусад байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу 384 лавлагаа хуулбар олгож, 413 хэрэглэгчид 5441 хадгаламжийн нэгжийг албан ажлын хэрэгцээнд түр ашиглуулах үйлчилгээ үзүүлсэн,
- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/-тай хамтран Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны танхимд нийт 15 хэлний 1 цогц орчуулгын системийг суурилуулж, техникийн өргөтгөл шинэчлэлт хийсэн,
- Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны болон Байнгын хороодын хуралдааныг шууд дамжуулах дотоод сүлжээний IPTV-г шинээр нэвтрүүлж, 200 орчим хэрэглэгчдийг холбож дуу, дүрсний өндөр нягтралтайгаар хүргэж ажилласан байна.

Улсын Их Хурлын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль эрх зүйн акт болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох САГ-2019/1/СТА-ТЕЗ



бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль, эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын Их Хурлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа хэдий ч хэвлэх цехийн өртөг, борлуулалтын орлогын бүртгэлийн арга зүй, хууль эрх зүйн актуудыг шинэчлэн нэмэлт өөрчлөлтүүдийг хийгээгүй байна.

Улсын Их Хурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн “Э-Тайлан” програм хангамж ашиглаж байна.

Харин Үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын алба бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт хийн 115 зөрчил дутагдлыг илрүүлж, холбогдох албан тушаалтнуудад танилцуулан, зөвлөмж өгч ажилласан байна.

Илэрсэн алдаа зөрчлийн 20.1 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилт, 19.5 хувийг дотоод ажил, ажлын үр дүнгийн үнэлгээний асуудал, 12.5 хувийг санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлагналын асуудал, 20.7 хувийг эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах асуудал, 29.2 хувийг үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр ашиг, өгөөжийг сайжруулахтай холбоотой байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улсын Их Хурлын даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.



## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Энэ нь Төсвийн байгууллагын хувьд орлогын бүрдүүлэлт, түүний тайлагналд анхаарч ажиллахтай холбоотой юм.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлогыг сонгон, сонгосон суурь үзүүлэлтийн 2.0 хувиар тооцож, материаллаг байдлын түвшинг 659.7 сая төгрөгөөр тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар дүгнэж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд УИХ-ын Тамгын газрын санхүүгийн тайланд түүвэр хийж, “Монгол Улсын Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн нэгжийн санхүүгийн тайланд Хараат бус аудитын компани аудитыг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр, тоогоор).

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ		1	-	-
2	ТЕЗ	1			
3	Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэн нь төсөл	1			
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитад хамрагдсан “Монгол Улсын Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улсын Их Хурлын даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 545.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 18.8 хувь буюу 102.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 81.2 хувь буюу 442.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Хүснэгт 2 (Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт, тоо, сая төгрөгөөр)

№	Байгууллагын ангилал	Үүнээс:											
		Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Ууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	3	442.9	-	-	-	-	3	442.9	-	-	-	-





Дүн	3	442.9	-	-	-	-	3	442.9	-	-	-	-
-----	---	-------	---	---	---	---	---	-------	---	---	---	---

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

УИХ-ын даргын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- УИХ-ын хэрэгжүүлж буй “Монгол Улсын Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2018 оны санхүүгийн тайланд тус төслийг хэрэгжүүлж буй НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс сонгосон хараат бус аудитын компани аудитыг гүйцэтгэсэн ба уг аудитаар зөрчил илрээгүй байна.
- Аудитын түүвэрт хамрагдсан УИХ-ын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 545.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүний 102.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 442.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

## 2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр 6 горим, сорилыг гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудал байхгүй болно.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нарийвчлан авч үзэх асуудал байхгүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Улсын Их Хурлын 1 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 33,113.2 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 30,428.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,684.9 сая төгрөгийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр төслөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын Их Хурал 2018 онд гүйцэтгэлээр нийт 32,394.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн ба үүнээс улсын төсвөөс санхүүжих орлого 30,216.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 110.2 сая төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслөөс 2,178.3 сая төгрөгийн орлогыг тус тус



сүрдүүлж, гүйцэтгэлээр 30,724.9 сая төгрөгийг зарцуулсан ба төсвийн гүйцэтгэл 92.8 хувьтай байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон 110.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, зарцуулалт нь 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Улсын Их Хурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Улсын Их Хурлын даргын төсвийн шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл оруулах ажлын биелэлтэд тайлант онд дотоод аудитын нэгжээс 3 удаа аудит хийж, аудитын тайлан, зөвлөмжийг холбогдох нэгжийн удирдлагад хүргүүлж ажилласан байна. УИХ-ын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт тус хяналтаар 90.6 хувьтай үнэлэгджээ.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгсний 2 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн хэрэгжилт 80.0 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурьдсан.



## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын Их Хурлын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

УИХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хэвлэх цехийн үйлдвэрлэлийн зардал, бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлогын бүртгэл хөтлөлт, тайлагналын талаар болон санхүү бүртгэл, бусад эрх зүйн актуудын шинэчлэл өөрчлөлтүүдийг тусгаагүй байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Тамгын газрын Хэвлэх цехийн бараа материал, тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын ажлын зардал буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлогын бүртгэлийн талаар холбогдох арга зүйг боловсруулан оруулах, мөн шинээр гарсан, өөрчлөгдсөн хууль эрх зүйн актуудын нэмэлт, өөрчлөлтүүдээр баяжуулалт хийх.

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 3.2 Төсөвт зардалтай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:



а) УИХ-ын хэвлэлийн цехийн хэвлэж буй төрийн мэдээлэл эмхэтгэлийн материалын болон тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын зардалд зориулан 2018 онд улсын төсвөөс 180.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан боловч Хэвлэх цехийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого нь бүтээгдэхүүний өртөгөө бүрэн нөхөж, ашигтай гарсан байна. Иймд Хэвлэх цехийн үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс санхүүжилт олгосон нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

б) Аудитын явцад УИХ-ын гишүүдийн батлагдсан төсөвт зардлуудын 2018 оны 12 дугаар сарын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд хөрөнгийн зарцуулалт, зориулалт нь тодорхой бус, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 442.9 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн байна.

### 3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх байх, Төсвийн үр ашиггүй зардал гарах.

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

- Батлагдсан төсвийг зарцуулахдаа холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, мөн бүрдэл дутуу ажил гүйлгээг хийж, бүртгэл тайланд тусгахгүй байх,
- УИХ-ын гишүүдэд холбогдох хуулийн дагуу санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэх талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллах,
- Хэвлэх цехийн зардалд зориулан олгож буй улсын төсвийн санхүүжилтийг бууруулах, цаашид үйлдвэрлэлийн түүхий эдийн болон тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын зардлыг үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүжүүлдэг байх арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



➤ **Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>520,879.9</b>	<b>500,538.2</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,557.2</b>	<b>597.0</b>
<b>АВЛАГА</b>	<b>29,593.7</b>	<b>7,902.2</b>
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>489,729.0</b>	<b>492,039.0</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,095,866.9</b>	<b>6,810,934.7</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,095,866.9</b>	<b>6,810,934.7</b>
Биет хөрөнгө	6,032,623.1	6,672,710.8
Биет бус хөрөнгө	63,243.8	138,223.9
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,616,746.8</b>	<b>7,311,472.9</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,630.7</b>	<b>12,319.3</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,630.7</b>	<b>12,319.3</b>
Өглөг	3,630.7	12,319.3
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,613,116.1</b>	<b>7,299,153.6</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,613,116.1</b>	<b>7,299,153.6</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,560,849.8	3,560,849.8
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,052,266.3</b>	<b>3,738,303.8</b>
Өмнөх үеийн үр дүн	2,449,057.5	3,052,266.3
Тайлант үеийн үр дүн	603,208.8	686,037.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,616,746.8</b>	<b>7,311,472.9</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>34,705,800.9</b>	<b>33,088,176.3</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,877,525.0</b>	<b>2,765,434.8</b>
Нийтлэг татварын бус орлого	2,741,175.9	2,267,497.5
Тусламжийн орлого	136,349.1	497,937.3
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>31,828,275.9</b>	<b>30,322,741.6</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	30,586,378.7	30,216,360.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,241,897.2	106,381.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,921,735.2</b>	<b>32,402,112.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>33,921,735.2</b>	<b>32,402,112.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>31,366,088.5</b>	<b>30,227,003.0</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,479,612.4	8,230,598.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	910,477.7	976,816.4
Хангамж, бараа материалын зардал	1,180,133.2	1,321,003.4
Эд хогшил, урсгал засварын зардал	67,698.7	48,553.9
Томилот, зочны зардал	1,536,786.5	1,694,017.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,595,224.6	2,945,869.9
Бараа үйлчилгээний бусад зардал	17,596,155.2	15,010,143.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,555,646.7</b>	<b>2,175,109.9</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>32,278.9</b>	<b>34,166.4</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	32,278.9	34,166.4
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,223,736.3</b>	<b>419,159.5</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,299,631.4	1,721,784.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>784,065.8</b>	<b>686,063.5</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>180,857.0</b>	<b>26.0</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>603,208.8</b>	<b>686,037.5</b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>34,405,903.8</b>	<b>32,504,788.1</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,516,310.6</b>	<b>2,178,255.7</b>
Тусламжийн орлого	2,516,310.6	2,178,255.7
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>31,889,593.2</b>	<b>30,326,532.4</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	30,586,378.7	30,216,360.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,303,214.4	110,171.8
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,593,396.5</b>	<b>30,708,300.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,593,396.5</b>	<b>30,708,300.0</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>30,040,049.3</b>	<b>28,533,190.1</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,485,507.1	8,242,844.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	908,503.4	959,954.1
Хангамж, бараа материалын зардал	1,169,333.9	1,217,197.7
Эд хогшил, урсгал засварын зардал	76,220.1	4,406.6
Томилот, зочны зардал	1,735,405.2	1,694,017.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,303,389.4	2,946,452.8
Бараа үйлчилгээний бусад зардал	16,361,690.3	13,468,316.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,553,347.2</b>	<b>2,175,109.9</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	32,278.9	34,166.4
Бусад урсгал шилжүүлэг	1,221,436.8	419,159.5
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,299,631.4	1,721,784.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,812,507.3</b>	<b>1,796,488.1</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,810,950.1</b>	<b>1,797,448.3</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,810,950.1</b>	<b>1,797,448.3</b>
Дотоод эх үүсвэрээр	1,810,950.1	1,797,448.3
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,810,950.1</b>	<b>-1,797,448.3</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,557.2</b>	<b>-960.2</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,557.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,557.2	597.0



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,146,256.5	6,146,256.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-136,349.1	-136,349.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,009,907.3	6,009,907.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	603,208.8	603,208.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,613,116.1	6,613,116.1
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,613,116.1	6,613,116.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,613,116.1	6,613,116.1
Тайлант үеийн үр дүн	686,037.5	686,037.5
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,299,153.6	7,299,153.6



#### 4.5 Аудит хийгдсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>33,113,174.2</b>	<b>30,683,964.3</b>	<b>2,429,209.9</b>	<b>92.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>31,199,874.2</b>	<b>28,982,544.0</b>	<b>2,217,330.2</b>	<b>92.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>30,818,026.5</b>	<b>28,629,218.2</b>	<b>2,188,808.3</b>	<b>92.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>8,912,880.5</b>	<b>8,242,844.4</b>	<b>670,036.1</b>	<b>92.5</b>
Үндсэн цалин	6,610,185.2	6,041,099.7	569,085.5	91.4
Нэмэгдэл	1,914,382.1	1,853,646.7	60,735.4	96.8
Унаа хоолны хөнгөлөлт	388,313.2	348,098.1	40,215.1	89.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>987,729.6</b>	<b>959,954.1</b>	<b>27,775.5</b>	<b>97.2</b>
Тэтгэврийн даатгал	629,278.4	623,302.6	5,975.8	99.1
Тэтгэмжийн даатгал	89,612.8	88,993.5	619.3	99.3
ҮОМШӨ-ний даатгал	71,690.2	68,709.8	2,980.4	95.8
Ажилгүйдлийн даатгал	17,922.6	16,717.1	1,205.5	93.3
Эрүүл мэндийн даатгал	179,225.6	162,231.0	16,994.6	90.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,412,252.0</b>	<b>1,217,197.7</b>	<b>195,054.3</b>	<b>86.2</b>
Бичиг хэрэг	168,566.7	142,457.2	26,109.5	84.5
Тээвэр, шатахуун	686,948.6	590,616.6	96,332.0	86.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,609.9	194,102.6	46,507.3	80.7
Ном, хэвлэл	197,060.0	170,824.3	26,235.7	86.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,066.8	119,197.0	(130.2)	100.1
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>97,385.9</b>	<b>96,763.5</b>	<b>622.4</b>	<b>99.4</b>
Багаж, техник, хэрэгсэл	35,000.0	32,716.9	2,283.1	93.5
Тавилга	15,000.0	18,376.9	(3,376.9)	122.5
Урсгал засвар	47,385.9	45,669.7	1,716.2	96.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,356,463.5</b>	<b>1,694,017.8</b>	<b>662,445.7</b>	<b>71.9</b>
Гадаад албан томилолт	1,058,000.0	663,912.9	394,087.1	62.8
Дотоод албан томилолт	830,172.6	589,376.1	240,796.5	71.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	468,290.9	440,728.8	27,562.1	94.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,466,513.9</b>	<b>2,950,124.0</b>	<b>516,389.9</b>	<b>85.1</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,434,513.9	2,921,647.6	512,866.3	85.1
Даатгалын үйлчилгээ	30,000.0	26,476.4	3,523.6	88.3
Тээврийн хэрэгслийн татвар	2,000.0	2,000.0	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,584,801.1</b>	<b>13,468,316.7</b>	<b>116,484.4</b>	<b>99.1</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	13,425,437.3	13,322,205.6	103,231.7	99.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	159,363.8	146,111.1	13,252.7	91.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>381,847.7</b>	<b>353,325.8</b>	<b>28,521.9</b>	<b>92.5</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>43,053.1</b>	<b>34,166.4</b>	<b>8,886.7</b>	<b>79.4</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	43,053.1	34,166.4	8,886.7	79.4
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>338,794.6</b>	<b>319,159.5</b>	<b>19,635.1</b>	<b>94.2</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,500.0	49,886.5	19,613.5	71.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,394.6	96,373.0	21.6	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	172,900.0	172,900.0	-	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,913,300.0</b>	<b>1,701,420.3</b>	<b>211,879.7</b>	<b>88.9</b>



Улсын Их Хурлын даргын төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тоног төхөөрөмж	1,913,300.0	1,701,420.3	211,879.7	<b>88.9</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>33,113,174.2</b>	<b>30,683,004.1</b>	<b>759,507.1</b>	<b>92.7</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>30,428,240.3</b>	<b>28,504,748.3</b>	<b>252,829.0</b>	<b>93.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	30,428,240.3	28,504,748.3	252,829.0	93.7
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>2,684,933.9</b>	<b>2,178,255.7</b>	<b>506,678.2</b>	<b>81.1</b>
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,684,933.9	2,178,255.7	506,678.2	81.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,557.2	(1,557.2)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	597.0	(597.0)	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>622.0</b>	<b>620.0</b>	<b>2.0</b>	<b>99.7</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага	1.0	1.0	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>622.0</b>	<b>620.0</b>	<b>2.0</b>	<b>99.7</b>
Удирдах ажилтан	93.0	91.0	2.0	97.8
Гүйцэтгэх ажилтан	500.0	500.0	-	100.0
Үйлчлэх ажилтан	29.0	29.0	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>622.0</b>	<b>620.0</b>	<b>2.0</b>	<b>99.7</b>
Ажлын албаны албан хаагч (АА)	502.0	500.0	2.0	99.6
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.0	29.0	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	91.0	91.0	-	100.0



**Хавсралт**

**5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2018 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит</b>	<b>САГ-2019/1/СТА-ТЕЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Улсын Их Хурал</b>			<b>мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	УИХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хэвлэх цехийн үйлдвэрлэлийн зардал, бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлогын бүртгэл хөтлөлт, тайлагналын талаар болон санхүү бүртгэл, бусад эрх зүйн актуудын шинэчлэл өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.	-	Зөвлөмж өгөх	УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Цолмон, Б.Лхагвасүрэн
2	УИХ-ын хэвлэлийн цехийн хэвлэж буй төрийн мэдээлэл эмхэтгэлийн материалын болон тоног төхөөрөмжийн сэлбэг, засварын зардалд зориулан 2018 онд улсын төсвөөс 180.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан боловч Хэвлэх цехийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого нь бүтээгдэхүүний өртөгөө бүрэн нөхөж, ашигтай гарсан байна. Иймд Хэвлэх цехийн үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс санхүүжилт олгосон нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.	-	Зөвлөмж өгөх	УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Цолмон, Б.Лхагвасүрэн
3	Аудитын явцад УИХ-ын гишүүдийн батлагдсан төсөвт зардлуудын 2018 оны 12 дугаар сарын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд хөрөнгийн зарцуулалт, зориулалт нь тодорхой бус, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 442,893.2 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн байна	442,893.2	Зөвлөмж өгөх	УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Цолмон, Б.Лхагвасүрэн
<b>Нийт дүн</b>		<b>442,289.4</b>			



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.